



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/23

Шивээговь сум

Малчдад цол тэмдэг, батламж
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, 3.1.8, “Сумын Засаг даргаас олгох шагналын журам”-ын 2.4, 3.1.4, 5.6, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Эрдэнэт мал сүргийнхээ тоо толгой өсгөж, малын ашиг шимийн гарц, чанар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлж сумын “Аварга малчин өрх”-өөр Шивээговь сумын 2 дугаар багийн малчин Осорын Доржсүх, Санжаагийн Байгалмаа, Наранбатын Ганзориг, Гончигийн Лхагвадулам нарыг шалгаруулж цол, тэмдэг, малчин Даваасамбуугийн Дашзэвэг, Түвшинжаргалын Мягмар нарт “Сумын мянгат малчин”-ы батламж, тэмдгийг тус тус олгосугай.

2. Аймгийн “Аварга малчин өрх”-өөр шалгарсан Баярсайханы Сүхбаатар, Цоожийн Чанцалдулам, аймгийн “Алдарт уяач”-аар шалгарсан Адъяасүрэнгийн Сугар нарт хүндэтгэл үзүүлэн, дурсгалын үнэ бүхий зүйлээр урамшуулсугай.


3. Шагнал, урамшуулалд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

4. Шагналд зарцуулагдах 2,504,000 (хоёр сая таван зуун дөрвөн мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа), нягтлан бодогч (Д.Сэлэнгээ) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын 2023 оны 02-р сарын 17-ны өдрийн 1123 дугаар захирамжийн 1-р хавсралт



СУМЫН АВАРГА МАЛЧИН ӨРХ, МЯНГАТ МАЛЧДЫН ШАГНАЛ, АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН ӨРХ, АЛДАРТ УЯАЧИД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2023.02.16

| № | Бүтээгдэхүүний нэр | Тоо хэмжээ /ширхэг/ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|-------------|--|---------------------|----------------|------------------|
| 1 | Сумын аварга малчны малгай | 4 | 150,000 | 600,000 |
| 2 | Мянгат малчны малгай | 2 | 150,000 | 300,000 |
| 3 | Мянгат малчны тэмдэг үнэмлэх | 2 | 50,000 | 100,000 |
| 4 | Чингис хааны Эш хөрөг | 4 | 35,000 | 140,000 |
| 5 | Аймгийн "Аварга малчин өрх", аймгийн "Алдарт уяач"-д хүндэтгэл үзүүлэх Мөнгөн аяга | 2 | 350,000 | 700,000 |
| 6 | Батламжийн хавтас | 2 /А5 хэмжээтэй/ | 10,000 | 20,000 |
| 7 | Өргөмжлөлийн хавтас | 2 /А4 хэмжээтэй/ | 12,000 | 24,000 |
| 8 | Хүндэтгэлийн урилга | 60 | 2,000 | 120,000 |
| 9 | Дагалдах мөнгөн шагнал /сумын "Аварга малчин өрх" | 2 | 200,000 | 400,000 |
| 10 | Дагалдах мөнгөн шагнал /Мянгат малчны батламж/ | 2 | 50,000 | 100,000 |
| Нийт | | | | 2,504,000 |